



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А153

Мандалгонь

"Гэр бүлийн өдөрлөг" зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн "Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлогын баримт бичиг батлах тухай" 2018 оны 03 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, эерэг харилцаа хандлага, хамтын үйл ажиллагааг сайжруулах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, эцэг эх, асран хамгаалагчийг зөвлөгөө, мэдээллээр хангах зорилгоор "Гэр бүлийн өдөрлөг"-ийг 2020 оны 09 дүгээр сарын 14-15-ны өдөр зохион байгуулсугай.

2. Гэр бүлийн өдөрлөг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, хөтөлбөрийг 2 дугаар, удирдамжийг 3 дугаар, шаардагдах төсвийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 2.193.500 (Хоёр сая нэг зуун ерэн гурван мянга таван зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 09 дүгээр сарын 25-ний өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн нийгмийн ажилтан (Б.Бүжинлхам), гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

49119010